



### АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2012 оны 07 сарын 27 өдөр

Дугаар А/᠓᠑

Улаанбаатар хот

“Архивын мэдээллийн аюулгүй байдлыг хангах тухай” гарын авлагыг батлах тухай

Мэдээллийн технологи-Аюулгүй байдлын аргууд-Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын үйл ажиллагааны дүрэм MNS ISO 17799.2007, Мэдээллийн технологи-Аюулгүй байдлын аргууд-Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо-шаардлага MNS ISO/IEC 27001:2009 стандартыг тус тус үндэслэн, Архивын ерөнхий газрын Мэдээллийн аюулгүй байдлын цогц бодлого, дэг, журмыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ

1. “Архивын мэдээллийн аюулгүй байдлыг хангах тухай” архивын ажилтнуудад зориулсан гарын авлагыг хавсралт ёсоор баталсугай.
2. Дээрхи гарын авлагыг 2012 оны 10 сарын 1-ний өдрөөс эхлэн өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг нийт төрийн архивын ажилтнуудад үүрэг болгосугай.
3. Гарын авлагыг үйл ажиллагаандаа мөрдүүлэх талаар удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч, хэрэгжилтэнд байнгын хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг төрийн архивын дарга нарт даалгасугай.
4. Гарын авлагыг хэвлүүлж, төрийн архивуудад шуурхай хүргүүлэхийг Захиргааны удирдлагын хэлтсийн дарга Д.Батхуяг, Мэдээллийн технологийн хэлтсийн дарга Ч.Оюунчимэг нарт тус тус үүрэг болгосугай.
5. Гарын авлагыг хэвлүүлэхэд шаардагдах зардлыг төсвөөс гаргахыг Ерөнхий ня-бо Б.Чинбатад зөвшөөрсүгэй.

ДАРГА  Д.ӨЛЗИЙБААТАР